



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (хуучин нэрээр)-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 80,368,720.00 (наян сая гурван зуун жаран найман мянга долоон зуун хорин) төгрөгийн балансын үнэ, 33,747,331.52 (гучин гурван сая долоон зуун дөчин долоон мянга гурван зуун гучин нэгэн төгрөг тавин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг Хилийн боомтын захиргаанд хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хилийн боомтын захиргааны дарга Ш.Лхачинжавд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт



Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /хуучин нэрээр/-ын үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй Хилийн боомтын захиргаанд балансаас
балансад шилжүүлэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ланд крузер прадо 150, 2784 УНӨ	2011/ 2012	80,368,720.00	33,747,331.52	46,621,388.48
	Нийт дүн		80,368,720.00 (наян сая гурван зуун жаран найман мянга долоон зуун хорин)	33,747,331.52 (гучин гурван сая долоон зуун дөчин долоон мянга гурван зуун гучин нэгэн төгрөг тавин хоёр мөнгө)	46,621,388.48 (дөчин зургаан сая зургаан зуун хорин нэгэн мянга гурван зуун наян найман төгрөг дөчин найман мөнгө)